

Банкуудын ипотекийн зээлийн тайлан

2017 оны 9 дүгээр сар


ХУРААНГУЙ:

- Тухайн сард банкууд 808 зээлдэгчид 49.6 тэрбум төгрөгийн ипотекийн зээл олгосноор ипотекийн зээлийн үлдэгдэл 4206.8 тэрбум төгрөгт, нийт зээлдэгчдийн тоо 92.6 мянгад хүрэв.
- Ипотекийн зээлийн үлдэгдлийн 77.5 хувь нь ОСИСТТБХ-ийн зээл байна.
- Нийт зээлийн үлдэгдлийн 95.7 хувь нь хэвийн, 2.4 хувь нь хугацаа хэтэрсэн, 1.9 хувь нь чанаргүй зээл байна.
- Ипотекийн зээлийн 99.5 хувь нь төгрөгөөр олгогдсон байна.
- Тухайн сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж жилийн хүү 12.5 хувь, дундаж хугацаа нь 17.9 жил байна.
- Орон нутаг дахь банкууд 204 зээлдэгчид 7.3 тэрбум төгрөгийн ипотекийн зээл олгосноор орон нутаг дахь банкуудын ипотекийн зээлийн үлдэгдэл 768.1 тэрбум төгрөгт, харин зээлдэгчдийн тоо 25.3 мянгад хүрчээ.
- Орон нутаг дахь банкуудын ипотекийн зээлийн үлдэгдэл нийт банкны салбарын ипотекийн зээлийн үлдэгдлийн 18.3 хувь, харин нийт зээлдэгчдийн 27.3 хувийг эзэлж байна.

1. Ипотекийн зээлийн үлдэгдэл


2017 оны 9 дүгээр сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 6.7 хувиар өсч 4206.8 тэрбум төгрөгт¹ хүрчээ.

Зураг 1. Ипотекийн зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт



Тайлант сарын эцэст ипотекийн зээлийн үлдэгдлийн 3260.0 тэрбум төгрөг нь ОСИСТТБХ², 828.3 тэрбум төгрөг нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, 118.4 тэрбум төгрөг бусад эх үүсвэрээр олгосон зээл байна.

Зураг 2. Ипотекийн зээлийн үлдэгдэл (эх үүсвэр)



¹ Үүнд банкуудын ОСИСТТБХ²-ийн хүрээнд МИК руу шилжүүлсэн зээлийг оруулж тооцсон болно.

² ОСИСТТБХ: “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоо бүрдүүлэх хөтөлбөр”. Үүнд жилийн 5 ба 8 хувийн хүүтэй зээл, эдгээр зээлд шилжүүлсэн зээл орно.

Зураг 3. Хугацаа хэтэрсэн, чанаргүй зээл




Тайлант сарын эцэст ипотекийн зээлийн үлдэгдлийн 95.7 хувь нь хэвийн, 2.4 хувь нь хугацаа хэтэрсэн, 1.9 хувь нь чанаргүй зээл байна.

Ипотекийн зээлийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь өмнөх сараас 0.4 нэгж хувиар буурчээ. 2017 оны 9 дүгээр сарын байдлаар хугацаа хэтэрсэн ипотекийн зээлийн 62.6 хувийг ОСИСТТБХ-ийн зээл, 33.7 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 3.7 хувийг бусад эх үүсвэрийн зээл эзэлж байна. Хугацаа хэтэрсэн ипотекийн зээлийн 0.7 хувийг гадаад валютын зээл бүрдүүлж байна.

Ипотекийн зээлийн 1.9 хувь нь чанаргүй зээл буюу өмнөх сараас өөрчлөгдөөгүй байна. Чанаргүй зээлийн 68.7 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 29.4 хувийг ОСИСТТБХ-ийн зээл, 1.9 хувийг бусад эх үүсвэрээр олгосон ипотекийн зээл бүрдүүлж байна. Гадаад валютаар олгосон зээлийн 28.1 хувь нь чанаргүй гэж ангилагдсан бөгөөд нийт чанаргүй зээлийн 6.7 хувийг бүрдүүлж байна.

2. Тайлант сард олгосон зээл


Зураг 4. Тайлант сард олгосон зээл



Тухайн сард банкууд иргэдэд 49.6 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгожээ.


Тайлант сард банкууд зөвхөн төгрөгийн зээл олгосон бөгөөд үүний 49.1 хувь ОСИСТТБХ-ийн, 50.9 хувь банкуудын өөрийн эх үүсвэрийн зээл байв.

Зураг 5. Нэг зээлдэгчид ногдох тухайн сард олгосон зээл



Нэг зээлдэгчид ногдох олгосон зээлийн хэмжээ 2017 оны 9 дүгээр сарын байдлаар 61.3 сая төгрөг байгааг байршлаар ялган харвал Улаанбаатар хотод 70.0 сая төгрөг, орон нутагт 35.7 сая төгрөг байна. ОСИСТТБХ-ийн хүрээнд олгосон зээл дунджаар 70.2 сая төгрөг байгаа бол банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл дунджаар 54.7 сая төгрөг байна.

Зураг 6. Тухайн сард шинээр олгосон, төлөгдсөн зээл



Тухайн сард 39.1 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, төлөгдсөн зээлийн хэмжээ өмнөх сараас 0.1 хувиар өсчээ. Үүний 9.8 тэрбум төгрөг нь хугацаанаас өмнө төлөгдсөн байна.

3. Зээлдэгчдийн тоо

Зураг 7. Тухайн сард зээл авсан зээлдэгчийн тоо




Тайлант сард нийт 808 зээлдэгч шинээр ипотекийн зээлд хамрагдсанаас 347 зээлдэгч “ОСИСТТБХ”-ийн зээлд, 461 зээлдэгч банкны өөрийн эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.

2017 оны 9 дүгээр сарын байдлаар нийт 92616 иргэн ипотекийн зээлтэй байгаагаас 68464 нь “ОСИСТТБХ”-ийн зээлд, 20389 нь банкуудын өөрийн эх үүсвэрийн зээлд, 3763 нь бусад эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.

4. Зээлийн хугацаа


Зураг 8. Ипотекийн зээлийн хугацаа



Тайлант сард банкууд 2-30 жилийн хугацаатай ипотекийн зээл олгосон бөгөөд жигнэсэн дундаж хугацаа нь 17.9 жил байна. Ипотекийн зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хугацаа 2017 оны 9 дүгээр сарын байдлаар 16.7 жил байна. Тухайн сард олгосон зээлийн дийлэнх буюу 61.3 хувь нь 16-20 хүртэлх жилийн хугацаатай байгаа бол нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 73.3 хувь нь 16-20 хүртэлх жил, 21.4 хувь нь 11-15 хүртэлх жил, 3.2 хувь нь 21-27 хүртэлх жил, 2.1 хувь нь 6-10 хүртэлх жилийн хугацаатай байна.

5. Зээлийн хүү

Зураг 9. Ипотекийн зээлийн хүү




2017 оны 9 дүгээр сард банкуудын олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 12.5 хувь байгаа нь өмнөх сарынхаас 0.5 нэгж хувиар өссөн байна.

“ОСИСТБХ”-ийн хүрээнд олгосон зээлийн хүү 8.0 хувь байсан бөгөөд банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 16.9 хувь байлаа.

6. Орон нутаг дахь банкуудын ипотекийн зээл

Зураг 10. Орон нутаг дахь ипотекийн зээлийн үлдэгдэл, санхүүжилтээр




Орон нутаг дахь банк (ОНБ)-уудын ипотекийн зээлийн үлдэгдэл³ 2017 оны 9 дүгээр сарын байдлаар 768.1 тэрбум төгрөгт хүрч, нийт банкны салбарын ипотекийн зээлийн үлдэгдлийн 18.3 хувийг бүрдүүлж байна. Харин зээлдэгчдийн тоо 25266-д хүрч нийт зээлдэгчдийн 27.3 хувийг эзэлж байна.

ОНБ-уудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 79.4 хувь буюу 609.7 тэрбум төгрөг нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл, 19.7 хувь буюу 151.0 тэрбум төгрөг

³ 2017 оны 9 дүгээр сараас эхлэн ипотекийн зээлийн үлдэгдлийг барьцаа хөрөнгийн байршлаар тооцож байгаа болно.


Зураг 11. Ипотекийн зээлийн үлдэгдэл, аймгуудаар



нь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 1.0 хувь буюу 7.4 тэрбум төгрөг нь бусад эх үүсвэрээр олгосон зээл байна. 2017 оны 9 дүгээр сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 99.98 хувь нь төгрөгөөр олгосон зээл байна.

ОНБ-уудын ипотекийн зээлийн үлдэгдлийг аймгуудаар авч үзвэл Орхон аймагт 15.6 хувь, Дархан-Уул аймагт 15.3 хувь, Дорноговь аймагт 9.0 хувь, Дорнод аймагт 7.3 хувь, Ховд аймагт 5.5, Увс аймагт 5.4 хувь нь ногдож байгаа бөгөөд эдгээр нь ОНБ-уудын салбарын нийт ипотекийн зээлийн 58.1 хувийг бүрдүүлж байна.


Зураг 12. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэл, аймгуудаар



ОНБ-уудын ипотекийн зээлийн үлдэгдэл⁴-ийн 96.0 хувь нь хэвийн зээл, 1.8 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 2.3 хувь нь чанаргүй зээл байна.

2017 оны 9 дүгээр сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 12.9 хувьтай байна. Тайлант сард орон нутаг дахь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 16.7 хувь байгаагаас Архангай (21.6 хувь), Баянхонгор (21.6 хувь), Өмнөговь (20.8 хувь), Сүхбаатар (20.3 хувь) аймгуудад хамгийн өндөр, Завхан (9.6 хувь), Булган (8.0 хувь) аймгуудад хамгийн бага хувьтай байна.

Зураг 13. Тухайн сард олгосон ипотекийн зээлийн ЖДХ, аймгуудаар




Орон нутаг дахь нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хугацаа 16.5 жил байгаа бөгөөд тайлант сард банкууд 2-30 жилийн хугацаатай зээл олгожээ.

⁴ МИК рүү шилжүүлсэн зээлийн дүнг хасаж тооцсон болно.

7. Барьцаа хөрөнгийн мэдээлэл


Зураг 14. Орон сууцны байршил, Улаанбаатар хот



Ипотекийн зээлийн үлдэгдлийн 81.7 хувь буюу 3438.7 тэрбум төгрөгөөр Улаанбаатар хотод, 18.3 хувь буюу 768.1 тэрбум төгрөгөөр орон нутагт байршилтай орон сууц худалдан авчээ.


Улаанбаатар хотод худалдан авсан орон сууцны 33.9 хувь нь Баянзүрх дүүрэг, 23.5 хувь нь Хан-уул дүүрэг, 22.9 хувь Баянгол дүүрэг, 8.6 хувь нь Сонгинохайрхан дүүрэг, 11.1 хувь нь бусад дүүргүүдэд байршилтай байна.

Зураг 15. Барьцаа хөрөнгийн байршил, орон нутаг




Орон нутагт худалдан авсан барьцаа хөрөнгийн 52.7 хувь нь хүн амын суурьшил харьцангуй их байдаг Орхон, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Ховд аймгуудад байршилтай байна.

Зураг 16. Барьцаа хөрөнгийн талбайн хэмжээ



Ипотекийн зээлийн үлдэгдлийн 90.7 хувь буюу 3814.3 тэрбум төгрөг 80м2 хүртэлх талбай бүхий орон сууц худалдан авахад зарцуулагджээ. 80 м2 хүртэл талбайтай зээлийн 85.3 хувийг ОБИСТТБХ-ийн эх үүсвэрээр, 12.2 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр, 2.5 хувийг бусад эх үүсвэрээр санхүүжүүлсэн байна.

Зураг 17. Барьцаа хөрөнгийн төрөл




Ипотекийн зээлийн үлдэгдэлд нийтийн зориулалттай орон сууцны зээл 97.0 хувь, хашаа, байшингийн зээл 1.9 хувь, амины орон сууцны зээл 1.1 хувийг тус тус эзэлж байна.

Ипотекийн зээлийн үлдэгдлийн 75.3 хувь нь нэмэлт барьцаагүй, 24.7 хувь нь нэмэлт барьцаатай зээл байгаа бөгөөд зээлдэгчийн 79.4 хувь нь буюу 73491 зээлдэгч худалдан авч буй орон сууцаа барьцаалан, нэмэлт барьцаагүйгээр зээл авсан байна.


8. Зээлдэгчийн мэдээлэл

Зураг 18. Зээлдэгчийн орлого



2017 оны 9 дүгээр сарын байдлаар ипотекийн зээлтэй нийт зээлдэгчдийн тоо 92616 байгаагийн 64.9 хувь нь 2 сая хүртэлх төгрөгийн өрхийн орлоготой бөгөөд 72.7 хувь нь Улаанбаатар хотод байршилтай орон сууц худалдан авчээ. Худалдан авсан орон сууцных нь төрлөөр ангилан харвал зээлдэгчдийн 92.4 хувь нь нийтийн зориулалттай орон сууц, 6.3 хувь нь хашаа байшин, 1.3 хувь нь амины орон сууцанд зориулан ипотекийн зээл авсан байна.


Зураг 19. Зээлдэгчийн орлого, барьцаа хөрөнгийн байршлаар, Улаанбаатар хот



Улаанбаатар хотод орон сууц худалдан авсан иргэдийн 32.6 хувь нь Баянзүрх, 23.5 хувь нь Баянгол, 19.9 хувь нь Хан-Уул, 12.0 хувь нь Сонгинохайрхан, 7.0 хувь нь Сүхбаатар, 2.8 хувь нь Чингэлтэй, 2.3 хувь нь алслагдсан дүүргүүдэд орон сууц авчээ.


Улаанбаатар хотод байршилтай орон сууцны зээлийн үлдэгдлийг дүүргүүдээр, орон сууц худалдан авсан иргэдийнх нь сарын орлогын түвшингээр нь ялган харвал Баянзүрх, Хан-Уул, Баянгол дүүргүүдэд орон сууц худалдан авсан зээлийн нийт ипотекийн зээлийн үлдэгдэлд эзлэх хувь орлогын түвшин бүрт 76-аас дээш хувийг эзэлж байна.

Зураг 20. Зээлдэгчийн орлого, барьцаа хөрөнгийн байршлаар, орон нутаг



Орон нутагт ипотекийн зээлээр орон сууц худалдан авсан иргэдийг өрхийн сарын орлогын түвшингээр нь ялган харвал 2 саяаас дээш орлоготой иргэдийн 50-иас дээш хувь нь хүн амын суурьшил харьцангуй өндөр Орхон, Дархан-Уул, Дорноговь, Дорнод аймгуудад орон сууц худалдан авчээ. 2 сая хүртэлх орлоготой иргэдийн 54.8 хувь нь дээрх 4 аймгаас гадна Увс, Өвөрхангай, Өмнөговь аймгуудад орон сууц худалдан авсан байна.


Зураг 21. Зээлдэгчийн насны ангиллаарх зээлийн үлдэгдэл



Нийт зээлдэгчдийн 76.4 хувь нь 25-45 насны иргэд байгаа бөгөөд эдгээр зээлдэгчид нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 80.2 хувийг эзэмшиж байна.

Бүх насны ангилал дахь иргэдийн 68.0-аас дээш хувь нь Улаанбаатар хотод орон сууц худалдан авчээ.

Зураг 22. Хамтран зээлдэгчийн тоо



Зээлдэгчдийн 79.4 хувь нь нэг хамтран зээлдэгчтэй, 15.7 хувь нь хамтран зээлдэгчгүй, 4.9 хувь нь 2 болон түүнээс дээш хамтран зээлдэгчтэй байна. Нэг хамтран зээлдэгчтэй зээлдэгчид нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 79.7 хувь буюу 3351.2 тэрбум төгрөгийн зээлийг эзэмшиж байна.

Хавсралт 1. Банкуудын ипотекийн зээл

Он	Сар	Ипотекийн зээлийн үлдэгдэл (сая төг.)	Үүнээс:	Тайлант сард шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа (жилээр)	Тухайн сард олгосон зээлийн жилийн ЖДХүү, (%)	Нийт зээлдэгч (тоогоор)	Үүнээс:
			ОСИССТБ хөтөлбөрийн зээл				ОСИССТБ хөтөлбөрийн зээлтэй
2010	12	333,776.6		9.6	16.0	16,700	
2011	12	669,662.8		12.9	14.8	26,869	
2012	12	845,204.4		13.0	15.3	29,887	
2013	12	1,938,945.3	1,248,633.8	16.1	9.9	48,320	30,600
2014	1	2,021,424.9	1,324,898.9	16.2	9.8	49,731	32,190
	2	2,121,802.6	1,382,084.1	16.1	9.9	53,611	33,346
	3	2,193,368.6	1,451,938.1	15.9	9.9	54,787	34,632
	4	2,280,503.5	1,538,506.8	16.0	9.8	56,137	36,081
	5	2,365,349.5	1,618,127.2	15.8	10.0	57,579	37,488
	6	2,440,007.1	1,684,583.9	15.2	10.5	58,793	38,659
	7	2,492,105.2	1,728,222.8	15.7	10.7	59,756	39,507
	8	2,553,827.2	1,780,078.3	15.6	10.5	60,851	40,405
	9	2,619,161.1	1,833,494.0	15.5	10.6	62,017	41,390
	10	2,703,792.6	1,903,636.6	15.8	10.4	63,652	42,772
	11	2,762,726.8	1,954,341.3	16.2	10.3	64,577	43,621
	12	2,844,706.3	2,027,952.9	16.7	9.9	66,334	45,283
2015	1	2,898,731.0	2,072,894.5	16.3	10.2	67,233	46,134
	2	2,949,116.5	2,121,339.7	16.6	9.7	68,126	47,108
	3	3,015,535.1	2,196,795.5	16.5	9.2	69,269	48,512
	4	3,082,551.7	2,263,794.5	16.6	9.6	70,498	49,691
	5	3,128,182.4	2,305,308.1	16.4	10.3	71,355	50,462
	6	3,192,029.1	2,363,999.7	16.4	9.6	72,412	51,438
	7	3,230,507.8	2,400,625.2	16.1	9.9	73,208	52,181
	8	3,267,175.5	2,433,968.6	16.3	10.0	73,949	52,858
	9	3,319,711.8	2,481,556.8	16.2	9.6	74,848	53,643
	10	3,370,510.2	2,534,505.4	16.8	9.4	75,877	54,612
	11	3,412,929.6	2,570,150.9	16.4	10.0	76,583	55,295
	12	3,432,957.6	2,590,987.6	16.7	8.8	77,105	55,830
2016	1	3,434,849.9	2,595,234.1	16.3	10.1	77,226	56,031
	2	3,459,596.6	2,623,837.0	16.6	9.2	77,673	56,577
	3	3,565,687.2	2,679,829.3	17.1	8.8	81,015	57,659
	4	3,625,870.6	2,751,292.4	16.7	8.2	82,156	59,001
	5	3,697,056.7	2,832,261.7	19.7	8.3	83,280	60,455
	6	3,792,276.2	2,929,375.2	19.1	7.7	84,906	62,080
	7	3,849,221.0	2,995,847.0	19.5	7.7	85,622	63,146
	8	3,886,362.9	3,029,623.4	19.0	8.4	86,221	63,729
	9	3,943,037.2	3,047,579.5	19.7	8.7	87,925	64,081
	10	3,950,186.6	3,052,251.0	18.1	9.1	88,044	64,277
	11	3,979,535.9	3,082,876.9	18.8	9.2	88,555	64,868
	12	4,018,298.5	3,115,908.9	18.6	10.3	89,156	65,412
2017	1	4,034,887.3	3,133,147.5	18.5	9.6	89,482	65,777
	2	4,062,800.9	3,158,120.1	18.2	10.3	89,823	66,166
	3	4,091,151.9	3,181,950.1	18.8	10.3	90,437	66,718
	4	4,112,246.3	3,199,452.5	18.0	10.5	90,850	67,076
	5	4,143,154.8	3,224,511.7	18.3	11.2	91,362	67,523
	6	4,177,179.5	3,224,764.8	18.0	11.4	91,916	67,894
	7	4,186,060.9	3,250,403.9	17.5	11.5	92,138	68,134
	8	4,196,170.0	3,256,238.4	17.6	12.0	92,347	68,311
	9	4,206,816.9	3,260,034.5	17.9	12.5	92,616	68,464

Хавсралт 2. Банкуудын ипотекийн зээл, нийслэл, аймгуудаар

Аймгууд	Ипотекийн зээлийн		Үүнээс ОСИСТБХ-ийн зээл		Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл* (сая.төг)	Чанаргүй зээлийн үлдэгдэл* (сая.төг)	Тухайн сард олгосон ипотекийн зээлийн жилийн ЖДХугацаа	Тухайн сард олгосон ипотекийн зээлийн ЖДХүү (жилээр)	Нийт зээлдэгчдийн тоо	Үүнээс: ОСИСТБ хөтөлбөрийн зээлтэй
	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь						
1 Улаанбаатар	3,438,697.0	81.7%	2,650,308.6	81.3%	37,254.3	52,631.8	218.7	12.4	67,350	50,953
2 Орхон	119,986.9	2.9%	105,780.7	3.2%	260.8	84.9	171.6	14.4	3,071	2,623
3 Дархан-Уул	117,896.5	2.8%	101,823.2	3.1%	531.2	585.1	214.4	11.0	3,639	3,014
4 Дорноговь	68,887.7	1.6%	56,281.7	1.7%	299.9	658.8	193.8	16.4	2,154	1,661
5 Дорнод	56,026.9	1.3%	47,738.0	1.5%	320.3	349.9	203.2	13.6	1841.0	1444.0
6 Ховд	41,929.1	1.0%	35,866.2	1.1%	132.1	423.1	134.1	14.3	1342.0	1027.0
7 Увс	41,660.0	1.0%	30,575.0	0.9%	1,134.1	2,555.3	230.2	9.3	1366.0	749.0
8 Баянхонгор	39,764.5	0.9%	35,893.4	1.1%	382.2	271.8	302.8	13.2	1299.0	1103.0
9 Сэлэнгэ	34,343.9	0.8%	25,754.4	0.8%	377.9	461.8	163.2	14.1	1312.0	873.0
10 Өвөрхангай	33,016.4	0.8%	23,396.7	0.7%	605.8	479.7	223.0	10.6	1311.0	687.0
11 Өмнөговь	29,715.8	0.7%	21,445.0	0.7%	91.8	600.9	141.2	15.9	971.0	628.0
12 Сүхбаатар	26,973.0	0.6%	19,689.7	0.6%	278.4	107.9	152.6	13.1	939.0	587.0
13 Баян-Өлгий	24,850.8	0.6%	12,700.3	0.4%	632.9	421.8	130.9	14.0	1157.0	344.0
14 Архангай	21,415.6	0.5%	17,538.2	0.5%	110.6	114.6	152.2	14.6	645.0	459.0
15 Хэнтий	20,772.5	0.5%	15,821.0	0.5%	146.2	193.8	250.1	10.8	660.0	435.0
16 Хөвсгөл	16,153.3	0.4%	8,510.8	0.3%	556.6	371.9	212.8	12.1	696.0	197.0
17 Говь-Алтай	15,778.7	0.4%	12,670.2	0.4%	84.5	95.3	207.7	16.1	576.0	439.0
18 Завхан	14,121.9	0.3%	8,009.6	0.2%	137.6	146.7	159.8	9.6	554.0	212.0
19 Төв	13,741.5	0.3%	9,320.3	0.3%	184.4	138.6	209.3	10.5	498.0	312.0
20 Дундговь	12,871.6	0.3%	9,674.4	0.3%	40.1	96.5	241.0	11.0	455.0	308.0
21 Говьсүмбэр	9,401.4	0.2%	7,218.1	0.2%	157.5	90.3	151.2	19.9	435.0	294.0
22 Булган	8,812.1	0.2%	4,019.1	0.1%	349.1	490.3	240.0	8.0	345.0	115.0
Нийт	4,206,816.9	100.0%	3,260,034.5	100.0%	44,068.4	61,370.7	214.8	12.5	92,616	68,464

* Банкуудын баланс дахь хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдлийг харуулав. Үүнд "МИК ОССК" ХХК-д шилжүүлсэн зээлийн дүн ороогүй болно.